

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

2024.10.30

Есөнзүйл сум

ЧХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/			Хэрэгжилтийн явц ()	Хэрэгжилтийн хувь
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ											
2.2. Санхүү, төсөв											
Зорилт 1. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.	1	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавина.	2021 - 2024	Санхүү алба						Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг тухай бүр нь шинэчлэн цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлыг төлөвлөж төрийн албан хаагчдийн цалинг цалингийн нэгдсэн системээр, Монгол банкаар дамжуулан олгож эхлэн ажиллаж байна. Хэрэгжилтэнд Сангийн яам, Төрийн сангийн хэлтэс хяналт тавин ажиллаж байна	100
	2	Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж,	2021 - 2024	Санхүү алба	Улс, орон нутгийн	11	Жилийн эцэс 11			Төсөвт байгууллагууд төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээллийг сар бүрийн 8-ны дотор shilendans.gov.mn сайтад мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэт тогтмол хугацаанд нь байршуулан хяналт тавьж улирал бүр илгээн ажиллаж. Санхүү хяналт дотоод	100

		хариуцлага тооцон ажиллана.			төс өв					аудитын алба улирал бүр хяналт шалгалт хийж хариуцлага тооцон ажиллаж байна	
	3	Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024	САНхүү алба, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн	7,2 сая	Хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 31 хувь	22 хувь			Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл авсан 2 иргэний гэрээний хугацаа дуусгавар болсоныг Хархорин сум дахь сум дундын шүүхэд хандан эвлэрлийн гэрээ байгуулсан боловч гэрээний хуваарийн дагуу зээлийг төлөөгүй тул 4647512 төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандан төлүүлэхээр ажиллаж байна. 2024 онд нийт 17 иргэн аж ахуй нэгжийн зээлийн хэмжээ хэвийн төлөлтэй хугацаа хэтрэлт байхгүй байна.	90
	5	Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа дотоодын давуу эрхийн зөрүү тооцох замаар орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.	2021 - 2024	САНхүү алба	Орон нутгийн төс өв	3	15			Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдах авах тухай хуулийн хүрээнд тендер зарлаж дотоодын аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг бүрэн хангаж тухай бүрт нь үр дүнг тооцон ажиллаж.	100
	6	Цахим тендер шалгаруулалтыг нэмэгдүүлж, цахим системийн хөгжил, шинэчлэлийг ашиглана.	2021 - 2024	САНхүү алба	Улс, орон нутгийн төс өв	83	85			Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль журам 2024 оноос шинэчлэгдэж, жил бүр худалдан авах ажиллагааны журмын дагуу худалдан авалтын ажил, үйлчилгээ үр дүнг тухай бүрт нь tender.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна. Мөн 2024 оноос эхлэн Боловсролын байгууллага, Эрүүл мэндийн байгууллага тус бүр дээр хоол хүнс бусад тендерийг өөрийн байгууллага дээрээ зарлаж ажилласан.	100

	7	Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ.	2021 - 2024	САНХҮҮ алба	5 сая Оро н нутг ийн төс өв	-	Олон нийт ийн үнэлг ээг сайж руула х		Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг гарган бүх шатны худалдан авах ажиллагаа болон гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалтыг тогтмол явуулж гарсан зөрчил дутагдалыг тухай бүрт нь арилгуулан ажиллаж байна. Иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна..	100
Зорилт 2. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.	1	Татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөн, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулна.	Жил бүр	Татвар ын байцааг ч	4,2 сая Сур галт сур тал чил гаа ны зар дал	87* Эх сурвал ж www.ta tvar.ov. gov.mn	96		2024 онд Есөнзүйл сумын Мөнхбулаг 2 дугаар баг, Тахилганы 1 дүгээр баг, Хайрханы 3 дугаар баг, Эрээний 4 дүгээр багийн Иргэдийн нийтийн хурлаар нийт 150 гаруй иргэдэд Малын тоон толгойн албан татварын талаарх хууль болон журын талаар танилцуулан мэдээлэл хийж ажиллалаа. Татвар төлөгч иргэн ААН байгууллагуудад Хувь хүний орлогын албан татварын талаарх сургалтын цахим хуудсаар 5 агуулгын хүрээнд 12 удаа бэлтгэн хүргэж ажилласан байна. Мөн Хөдөөний Тахилга 1 баг 40 өрхөөр тойрч албан шаардлага хүргүүлэн малын тоо толгойн татварын талаар мэдээ мэдээлэл хүргүүлж татварын бүрдүүлэлтийг хурааж ажиллаж байна Хувиараа бизнес эрхлэгч иргэдэд хувь хүний орлогын албан татвар талаар болон татварын тайлан илгээлтийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөн ажиллаж байна. Сумын хэмжээнд нийт татвар төлөгч иргэдэд багийн хуралаар дамжуулан мэдээ мэдээлэл хүргэсэн. 1-р багаар 1 удаа тойрон өрх тус бүрээр нь орж мэдээ мэдээлэл тараасан. 3-р багаар тойрон мэдээ мэдээлэл	90

										тараасан. 4-р багаар 1 удаа тойрон өрх бүрт мэдээлэл хүргүүлсэн. Цахим орчинд цаг алдалгүй -мэдээлэлээр ханган ажилласан. Мөн ирээдүйд татвар төлөгч олох хэрхэн ашигтай талаар 9-12-р ангийн 30 гаран хүүхдэд сургалт орон сургалт сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна.	
Зорилт 4: Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглалын менежментийг сайжруулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	2	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулна.	2021 - 2024	САНхүү алба						Орон нутгийн төсвийн байгууллагууд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулж сар бүр хугацаанд нь shilendans.gov.mn сайтад мэдээ мэдээллийг бүрэн оруулж хэвшсэн. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд “Шилэн дансны тухай хууль”-ийн талаар анхан шатны мэдэгдэхүүн өгч ажилласан.	100
	5	Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.	2021 - 2024	САНхүү алба						Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, бүртгэл мэдээллийн үнэлгээ тайланг ил тод нээлттэй болгож. Өмч эзэмшигчдийн хариуцлагыг нэмэгдүүлж гэрээг жил бүр шинэчлэн байгууллаж ажилласан. Мөн сар улирлаар мэдээ тайланг бэлтгэн жилд хагас бүтэн жилээр тооллого явуулж, өмч хамгаалах комиссын хийсэн ажлын үнэлгээг тухай бүрт нь үнэн зөв гарган ажиллаж байна. Мөн жилийн эцэс тайлан мэдээг програмд оруулан гэрээг дүгнүүлж ажилласан.	100
Бүлгийн дүн										97.7	
2.3. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа үйлчилгээ											

Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлэх бодлого баримталж, бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлж хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангана.	2	Цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг	117,9 сая Малчдын хөрөнгө	-	Цөм сүргийн мал 100 хувь, бог малын хээлтүүлэгч 30 хувь эзэмжүүлсэн байна.			2024 онд хээлтүүлэгч малын судалгааг гаргаж Хүнс Хөдөө Аж Ахуй газарт хүргүүлэн дутагдалтай байгаа хээлтүүлэгч малыг шинээр бойжуулах ажлыг сумандаа зохион байгуулж, шинээр 50 хурга ишиг 30 бойжуулан малыг ангилан эзэмжүүлэн бүртгэлжүүлэх ажлыг хийж гүйцэтгээд байна. Малын индексжүүлсэн даатгалд 60 өрхийн адуу 250, үхэр 80, хонь 14351, ямаа 1435, нийт 16116 толгой малыг хамруулсан. Сумын хэмжээнд 3 өрхөд Хуц 320 Ухна 250 хээлтүүлэгчийг суурилан малын гоц халдварт өвчний вакциныг хувийн мал эмнэлэгийн байгуулагатай хамтран зохион байгуулан эзэмжүүлсэн хээлтүүлэгч малын бүртгэл мэдээллийн санд оруулан ажиллалаа.	100
	3	Мал сүргийг бэлчээрийн даацад тулгуурлан сүргийн тоо толгойг зохистой хэмжээнд барьж, чанартай малтай малчдыг урамшуулан, зарим иргэдийг малжуулах төсөлд хамруулан залуу малчдыг бэлтгэж, тэднийг туршлага судлуулах дотоод, гадаадын арга хэмжээнд хамруулна.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг	Улс, орон нутгийн төсөв	Бэлчээрийн даац 2,8 дахин хэтэрсэн.	Бэлчээрийн даац хэтрэлтийг 0,4 хувиар бууруулсан байна.			Сумын хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 08 өдрийн байдлаар адуу 250 үхэр 200 хонь 4800 ямаа 1650 толгой малыг зах зээлд борлуулсан байна. Мөн зах зээлд 1000 толгой малыг борлуулах тал дээр малчтай хамтран ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэх сангаас малжуулах төсөлд 11 өрхийн 103 сая төгрөгөөр малжуулаад байна. Мөн малжуулахад хамрагдсан малчин өрхийг малчны зөвөлгөөнд хамруулаад байна	90
	4	Газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг	57,0 сая, Хоршоог хөгжүү	94 өрх, фермерт 1915 үхэр,	Аж ахуй эрхлэгчдийн тоо			Газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхрийн эрчимжсэн аж ахуйг Шилмэл сүрэг хоршоо эрхэлж байна. Мөн хоршоо	50

		үхрийн эрчимжсэн аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.			лэх сан 26.0 сая Малчдын хөрөнгө	7 иргэнд 220 бүлэг, 4 иргэн, ААН-д 1352 тахиа, 3 иргэн, ААН-д 75 гахай байна.	4 хувиар өссөн байна			хөгжүүлэх сангаас сүү сүүн бүтээгдэхүүнтий үйлдвэрлэл эрхлэдэг шилмэл сүрэг хоршоонд хоршоо хөгжүүлжх сангаас 50 сая төгрөгийг олгоод байна	
	5	Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулан, түүнийг газар талбай, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үр ашигтай ажиллуулна.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг						Сумын аюулгүй нөөцдөө 50 тн өвс 40 тн тэжээлийг бэлтгээд байна. Малчдын түвшинд 1058 тн өвс, 353 тн гар тэжээл, 453 тн давс хужир шүү бэлтэж, малчдын түвшинд хөнгөлттэй үрийн будаагаар тариалалт хийж 200 тн ногоон тэжээл хураан аваад байна. Дэлгэрэх аз хур ХХК нь малын ногоон тэжээлийг 170 гад тариалалт хийж 1 боодол өвсийг 12,000 төгрөгөөр, 1 портор ногоон тэжээлийг 200,000 төгрөгөөр малчдад нийлүүлж ажилласан.	90

	6	“Малын тоо толгойн албан татварын тухай” хуулийн дагуу татварын хувь хэмжээг тогтоохдоо бэлчээрийн даац, малын тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг	2,7 тэр бум Малын тоо толгойн албан татвар		Татварыг төвлөрүүлж зориулалтын дагуу зарцуулсан байна.		Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 07 өдрийн 3/01 тогтоолоор малын тоо толгой албан татварыг адуу 1000, үхэр 500, хонь 500, тэмээ 500, ямаа 1000 төгрөгөөр тогтоосон, 2023 оны малын эцсийн тооллогоор 172206 тооллогдож, нийт сумын татвар 233,258,200 төгрөг төвлөрхөөс 2024 оны 11 сарын байдлаар 73,637,400 төгрөгний татвар төвлөрсөн байна.	90
	9	Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг	160,0 сая төсөл хөтөлбөр	-	1-ээс доошгүй иргэн, ААН		2024 онд сумын худалдан авах, ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгийн төсөвт хөрөнгөөр хийгдэх арга хэмжээний нэг болох “Малын сүү, махны тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ”-ний дагуу Улаанбаатар хотын Монветмед ХХК-аас Meatsensor, Heatsensor duo, Readsensar2 зэрэг тоног төхөөрөмжүүдийг авч сүү, сүүн бүтээгдэхүүн бэлтгэх үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Суманд бод, бог малын хашаатай айл өрх 470, трактор 4, хадуур 272, усны помп 80, GPS 50, монгол гэрийн сөхдөг рам 584 байна. Төрөөс олгож буй ажлын байрыг дэмжих 3 хувийн хүүтэй зээлэнд сумын нийт 38 өрхөд 275,100,000 төгрөгний хөнгөлттэй зээл олгогдоод байна.	100
Зорилт 2. Малын халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэж тайван байдлыг хадгалан, мал, амьтны гаралтай түүхий эд,	1	Мал сүргийг угаалга, тарилга, туулгалтад бүрэн хамруулж, малын эмч болон мал эмнэлгийн нэгжийн тоог нэмэгдүүлэх замаар үйлчилгээний	2020 - 2024	Малын эмч	655,0 сая Орон нутгийн төсөв	-	Төлөвлөгөөт арга хэмжээний гүйцэ		2024 онд мал эмнэлэгийн үйлчилгээнд давхардсан тоогоор 445061 толгой малыг мал эмнэлэгийн үйлчилгээнд хамруулхаар төлөвлөж 401554,9 толгой малын буюу 90% гүйцэтгэлтэй байна. “Чин дөрвөн мэнд” хувийн мал эмнэлэг нь графикийн дагуу биобэлдмэлийг татан авч мал эмнэлэгийн нэгдсэн	100

<p>бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, экспортлох боломжийг бүрдүүлнэ.</p>		<p>чанар, хүртээмжийг сайжруулна.</p>			<p>446,0 сая үйлчилгээний хөлс</p> <p>208,0 сая вакцины үнэ</p>		<p>тгэлээр</p>		<p>системд төлөвлөлтийг оруулан цусан халдварт 750 бод, Дуут хавдар 380 бод тус тус хамруулж давхардсан тоогоор 77200 толгой малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 100 хувь хийж гүйцэтгэсэн мөн бруцеллэз өвчний вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Чин дөрвөн мэнд” хувийн мал эмнэлгийн малын эмч В.Сугаррагчаа 2023 оны 08 сарын 14 өдрийн А/104 дугаар захирамжаар бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн тугал 650, хурга 17200, ишиг 9800 нийт толгой малд тун вакциныг 99% хувь, оны гоц халдварт “Боом” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Чин дөрвөн мэнд” хувийн мал эмнэлгийн малын эмч В.Сугаррагчаа 2024 оны 04 сарын 10 өдрийн А/46 дугаар захирамжаар гоц халдварт боом өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 4 -р багийн бод 1000, бог 1900 нийт 2900 толгой малд 2000 тун вакциныг 98,7 хувь, гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Чин дөрвөн мэнд” хувийн мал эмнэлгийн малын эмч В.Сугаррагчаа 2024 оны 06 сарын 03-ны өдрийн А/03 дугаар захирамжаар гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн бод 8000 толгой мал таригдахаар төлөвлөсний дагуу 7905 толгой үхэрийг 98,7 хувь, “хонины цэцэг” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Чин</p>
---	--	---------------------------------------	--	--	---	--	----------------	--	--

										<p>дөрвөн мэнд” хувийн мал эмнэлгийн малын эмч В.Сугаррагчаа 2024 оны 06 сарын 03-ны өдрийн А/03 дугаар захирамжаар гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн бог 28000 толгой мал төлөвлөснийг 27730 толгой хонь буюу 99 хувьтай тус тус хийж гүйцэтгэсэн болно. Шимэгчдэх өвчнөөс урьдчилан сэргийлэх мал угаалгын үйлчилгээд хонь-90000, ямаа-55000, үхэр-6000 нийт 151000 мал угаалгад, Туулгалтанд бод-11000, бог-152179, нохой-732,Боловсруулалтанд бод-10000, бог-100000 хамруулхаар төлөвлөн мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөгөөг оруулан гүйцэтгэл хяналт тавин мал эмнэлгийн нэгдсэн системд оруулан ажиллаа.Үүнд мал угаалгын үйлчилгээд 25 өрхийн 15000 хонь, 25 өрхийн 500 ямаа мал угаалгад хамрагдсан. Туулгалтанд 604 өрхийн 6647 үхэр, 178 өрхийн 4322 адуу, 632 өрхийн 82163 хонь, 160 өрхийн 17593 ямаа нийт 11700 толгой мал 99% -тай хамрагдсан. Боловсруулалтанд 357 өрхийн 68689 хонь, 141 өрхийн 17066 ямаа, 356 өрхийн 4888 үхэр, 36 өрхийн 1180 адуу нийт 110000 толгой мал 92% -тай хамрагдсан. 2100м2 хашаа хороог ариутгасан гүйцэтгэл 100%, Бэлчээрийн талбайн сэг зэм устгал 4200м2 100%, гүйцэтгэн мал эмнэлгийн нэгдсэн системд оруулан баталгаажуулж холбогдох тайлан мэдээг хугацаанд нь гарган явуулсан.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

	2	Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр бүх сумын малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг цахимжуулна.	2021 - 2022	Малын эмч					Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичин, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг 100% цахимжуулсан.	100
	3	Мал сүрэгт түүврийн аргаар шинжилгээ хийж, түүний дүнг үндэслэн тухайн бүс нутгийг мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болохыг баталгаажуулж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдүүлнэ.	2020 - 2024	Малын эмч	Оро н нутг ийн төс өв	-	Табл етаар ханга гдсан малы н эмчи йн тоого ор		Гоц халдарт бог малын мялзан, бог малын цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалтыг 2 өрхийн 9 тугал, 13 ишиг, 13 хурганаас дээж авч аймгийн мал эмнэлэгийн газарт хүргүүлсэн. мөн итвэхгүй тандалтыг 4 багийн 50 өрхөд хийсэн байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины мониторинг 3 өрхийн 18 бяруу хамруулан цусны дээжийг цуглуун аймагийн мал эмнэлэгийн газарт хүргүүлсэн. 8 сард бруцеллез өвчний тандалт 600 эцэг малын цусны дээж аван аймгийн мал эмнэлэгийн газарт хүргүүлсэн. Мөн сүрьеэлүүр 80 үхэрт, ямлуур 80 адуунд арьсны сорил тавьсан.	100
	4	Малчдыг малын эм, био бэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх сургалт, мэдээллээр хангаж, эмийн үнэд хяналт тавина.	2020 - 2024	Малын эмч	Улс, оро н нутг ийн төс өв	Сургалт суртал чилгааны тоогоор	700		2023, оны 4 сарын 11 өдөр, 2024 оны 04 сарын 17-ны өдрүүдэд УБхотоос Монгол витнет ТББ урьж малчидад малын эм, био бэлдмэлийг зохистой хэрэглэх сургалтыг сумын нийт малчидад хийсэн. Мөн багийн хурал болон малчидын хотонд очих үедээ малын эмийн зөв зохистой хэрэглээний талаар малчидтай ярилцан гарын авлага тараах материалыг тарааж өгч	100

										байна. цахим орчинд Есөнзүйл мал эмнэлэгийн тасаг хаягаар малчидад мэдээ, мэдээллийг хүргэдэг.	
	5	Мал эмнэлгийн газрын лабораторийг мах, сүүнд шинжилгээ хийдэг /эм, тарианы үлдэгдэл илрүүлэх/ тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2022	Малын эмч	16,6 сая Орон нутгийн төсөв	-	Лабораторийн тоног төхөөрөмжөөр хангасан байна			ОНСангийн хөрөнгө оруулалтаар мах, сүүнд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх багаж авхаар төлөвлөн “Монветмет” малын эм, багаж нийлүүлдэг байгуулагатай гэрээ хийн 10.000.000 төгрөгөөр худалдан авч мах сүүнд антибиотик илрүүлэх үйл ажиллагааг эхлүүлээд байна.	100
Зорилт 3. Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ нэр төрлийн таримлыг тариалах замаар импортын хэрэглээг бууруулна.	1	Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариаланчдыг үр, бордоо, техникийн дэмжлэгт хамруулан, дотоодын хэрэгцээний үр тарианы 60, төмс, хүнсний ногооны 70 хувийг тус тус хангана.	2021 - 2024	Хөдөө аж ахуйн тасаг	Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, хувийн хэвшил	Хүн амын хэрэгцээ хангамж: гурилын 3782 хувийг хангах уйц ургац төмс 103,5 хувь, хүнсний ногоо 28,9 хувь, жимс, жимсгэнэ 0,06 хувь			2024 оны хувьд Газар тариалангийн эргэлтийн талбайг сайжируулж тариаланчдад 80% хөнгөлттэй нарийн ногооны 10 төрлийн үр, төмсний үр зэргийг хөнгөлөлттэй болон үнэгүй олгосон. Дотоодын хүнсний ногооны хэрэгцээгээ сумын хэмжээнд 100% хангагдсан. 2 иргэнд нарийн ногооны хүлэмж үнэгүй олгосон.	90	

	2	Сумдын атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэн, отор нүүдлийг багасгаж, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.	2021 - 2024	Хөдөө аж ахуйн тасаг					Сумын хэмжээнд нийт 200 га талбайд ногоон тэжээл тариалж, сумын аюулгүй нөөцдөө 500 боодол өвсийг 12000 төгрөгөөр бүрдүүлээд байна. Мөн 50 шуудай үрийн будаа хөнгөлттэй үнээр худалдаалж, малчдын тусгай хэрэгцээний 15 га талбайд таруулж 30 тн тэжээллийг бэлтгэн авсан	90
Зорилт 4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1	Хүн амын хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах замаар шимт, тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулна.	2021 - 2024	Хөдөө аж ахуйн тасаг, Ждү					Хүнсний аюулгүй байдал, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний салбарын мэдээллийн сан бүрдүүлэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын цахим системд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 7 дэлгүүр болон гал тогоо бүхий 4 газар бүртгүүлсэн. Тухайн орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай, зохион байгуулан Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийн сан шинээр үүсгэн ажиллаж байна. Худалдаа үйлчилгээний-7, Ахуйн үйлчилгээний-5, Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл-2, Оедол-1, Үсчин-1, Сур суран эдлэл-8, Нэхий эдлэл-5, Сүү, сүүн бүтээгдэхүүн-15, Дугуй засвар-2, Блок үйлдвэрлэл-1, Бичиг хэрэг-1, тогтмол үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр иргэдийн үүсгэн байгуулсан аж ахуй нэгж компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт 1 удаа зохион байгуулж ажиллаа. Мөн гарааны бизнес эрхлэхтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг тухай бүр нь	100

										таниулан ажиллаж байна. 7 хоног бүрийн 1 дэх өдрийн 12 цагаас өмнө Алтан жолоо хүлэг ххк, Баян үйлст хайрхан ххк, Дөрвөн хайрхан ххк, дэлгүүрүүдээс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг авч нэгтгэн хүн амын хүнсний хангамжийн хоногийн нөөцийн тооцоог хийж Хүнс хөдөө аж ахуйн газарт 1 өдрийн 14 цагаас өмнө программд оруулан мэдээллийг хугацаанд хүргэн ажиллаж байна.	
Бүлгийн дүн										92.8	
2.5. Барилга, хот байгуулалт, газрын харилцаа											
Зорилт 2. Эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой орон нутгийн дэд бүтцийг бий болгож, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	1	Сумдын төвийн доторх хатуу хучилттай авто замын сүлжээг үе шаттайгаар нэмэгдүүлэн, Улаанбаатар Арвайхээрийн чиглэлийн 60 км авто замын шинэчлэлийг хийнэ.	2020 - 2024 он	ЗДТГ дарга						Сумын төвөөс засмал зам хүртлэх хатуу хучилттай засмал зам тавьх зураг төсвийг улсын төсвийн хөрөнгөөр хийлгээд байна. Суман доторхи 2,7 км засмал зам тавих зураг төсвийг 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр хийлгээд байна. Засмал зам тавих ажил Тендер шалгаруултын явцтай үргэлжиж байна. орон нутгийн төсвийн хөрөнгөөр ын 2022, 2024 онд сумын төвийн замыг 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр засварийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Мөн Улаанбаатар Арвайхээрийн чиглэлийн 60 км авто замын шинэчлэлийг хийж дуусаад байна.	100
	8	Сумдын төвд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг бий болгон аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрхүүдийг холбон, орон	2020 - 2024 он	ЗДТГ дарга						Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байр, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг бохир цэврийн шугманд холбох ажил хийгдэж байсан боловч гүйцэтгэгч байгууллага нь үйл ажиллагаа санхүүжилт тасарсан гэсэн шалтгааны улмаас ажил нь зогсоод байна. 2022, 2024 онд сумын	70

		сууцжуулах нөхцөлийг бүрдүүлж, авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерээс хамгаалах далан сувгийг төлөвлөлтийн дагуу хийнэ.							төвийн замыг 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр засварийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс сумын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч 2 цамхагт гэрэл шинээр бий болгон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваад байна. Сумын хэмжээнд нийт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сумын төвийн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор 10 цамхагт гэрлийг 4 жилийн хугацаанд байрлуулан ажилласан байна. 2024 онд байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр сумын Даянгийн гүүрийг кольцо тавьж засварлах ажлыг хийж гүйцэтгээд байна.	
	9	Сумдын гэр хороолол, багуудад иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулж, Арвайхээр суманд аймгийн Алдартнуудын цэцэрлэгт хүрээлэн бүхий талбайг байгуулна.	2021 - 2024 он	ЗДТГ дарга					Сумын 90 жилийн түүхт ойн арга хэмжээний хүрээнд сумын төсвөөс болон иргэдийн хандив тусламжаар гэр хорооллуудын айл өрхүүдийн хашааг оохордон нэгдсэн нэг өнгөтэй болгоод байна. Мөн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс сумын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч 4 цамхагт гэрэл шинээр бий болгон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваад байна. Сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнг тухай онд Гүнд агсны нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн болгон Гүнд агсны болон Хөгжил нэгдлийг үүсгэн байгуулагч иргэдийн гэрэлт хөшөөг иргэдийн хандиваар бүтээн байгуулж цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн асуудлыг бүрэн шийдвэрлэснээр залуучууд хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрөөх аятай тухатай газар бий болоод байна.	100

Зорилт 3. Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ нэр төрлийн таримлыг тариалах замаар импортын хэрэглээг бууруулна.	2	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	ГХБХ БГ 2021-2024	Улсын төсөв	-	Цахим системийн хэвийн ажилла гааг хангаж, үйл ажилла гаанда а тогтмо л ашигла сан байна.			“Лэнд менежер”- праграм нэвтэрснээс иргэний нэр дээрхи газрыг кадастрийн мэдээлэлийн санд бүртгэлтэй эсэхийг шалган хувийн хэргийн баяжилт хийж ажиллаж байна. Сумын мастер төлөвлөөгөөгтэй уяалдуулан Газар зорион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг жил болгон Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн батлуулж иргэдэд хөнгөн шуурхай хурдан үйлчилж байна.	90
	3	Аймгийн болон сумдын төв, суурин газруудад хийгдсэн хаягийн зургийг шинэчлэн, хаягжилтын мэдээллийн сан үүсгэж, төрийн байгууллагын мэдээллийн бусад сантай холбоно.	ГХБХ БГ, Сумдын ИТХ, ЗДТГ, УБХ 2021-2023	Улсын төсөв		Аймгийн хэмжээн д хаягийн мэдээллийн сангийн өгөгдөл мэдээллийг засварлаж дууссан байна.			Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хаягжуулалтыг баталсан. Үүнтэй холбогдуулан хаягийн мэдээлэлийн санд өгөгдөл үүсгэж тогтмол хөтөлж ажиллаж байна.	70
Бүлгийн дүн									86%	
Бүлгийн дундаж									92.1%	

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ